

Шагналууд

Бизон аваргыг нэг шалтгаанаар аварга гэж дууддаг.

Бизон аварга нэгэн бэлэг хүлээж авсан байна. Энэ бэлэг нь n тавиуртай шилэн шүүгээ ба тэр өөрийнхөө бүх бэлгийг шүүгээндээ тавихаар шийдсэн. Түүний бэлэгнүүдийг дараах хоёр хэсэгт хувааж үзэж болно: медальнууд болон цомнууд. Бизон аваргад a_1 нэгдүгээр байрын цом, a_2 хоёрдугаар байрын цом, a_3 ширхэг гуравдугаар байрын цом мөн үүнээс гадна b_1 алтан медаль, b_2 мөнгөн медаль, b_3 хүрэл медаль байна.

Мэдээж хэрэг шагналууд шүүгээнд сайхан харагдах ёстой, тиймээс Бизон дараах дүрмийг дагахаар шийдсэн:

- аль нэг тавиур дээр медаль болон цом хоёулаа байж болохгүй;
- таваас илүү цомтой тавиур байж болохгүй;
- арваас илүү медальтай тавиур байж болохгүй.

Хэрэв бид эдгээр бүх нөхцлийг биелүүлж шагналуудыг байрлуулж чадах бол Бизонд туслая.

Input

Эхний мөр нь a_1, a_2, a_3 бүхэл тоонуудыг агуулна. Дараагийн мөр b_1, b_2, b_3 бүхэл тоонуудыг агуулна. Гуравдугаар мөрөнд n ($1 \leq n \leq 100$) бүхэл тоо байна. $(0 \leq a_1, a_2, a_3 \leq 100)$ $(0 \leq b_1, b_2, b_3 \leq 100)$

Мөрөн дэх тоонууд нь нэг зайгаар тусгаарлагдана.

Output

Хэрвээ бүх шагналуудыг заасан нөхцлийн дагуу байрлуулж болох бол "YES" (хашилтгүйгээр) гэж хэвлэнэ. Эсрэг тохиолдолд "NO" (хашилтгүйгээр) гэж хэвлэнэ.

Example

Input 1:

```
1 1 1
1 1 1
4
```

Output 1:

```
YES
```

Input 2:

```
1 0 0
1 0 0
1
```

Output 2:

```
NO
```

